БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 07 өдөр Дугаар А/220 Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн
дуудлага худалдааг дахин зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 188 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2026 оны А/107 дугаар захирамжийн хүрээнд зохион байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдаанд ялагч тодроогүй 2 (хоёр) байршилд 2026 оны 10 дугаар сарын 27-ны өдөр дахин цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

1226100626

AJIL\2026 он ажил\захирамж